



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/566

Хэрлэн сум

Галт зэвсгийн үзлэг, тооллого, татвар
хураалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Галт зэвсгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, 28.1.3, 28.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд явагдаж байгаа “Зэвсэг-2022” нэгдсэн арга хэмжээг Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, галт зэвсгийн бүртгэл, тооллогын ажлыг аймгийн хэмжээнд эрчимжүүлэх, бүртгэлгүй нуугдмал галт зэвсгийг илрүүлэх, гэрчилгээжүүлэх улсын галт зэвсгийн нэгдсэн санд баяжилт хийх, татварын орлого бүрдүүлэлт, хураалтын ажлыг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулж, явуулахыг Цагдаагийн газар, (Цагдаагийн хурандаа Д.Батхүү), Татварын хэлтэс (А.Гантөмөр) нарт, иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг идэвхтэй оролцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.Нэгдсэн дүнг 2022 оны 12 дугаар сарын 08-ны дотор танилцуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Д.Батхүү)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ